



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2016 оны
үйл ажиллагаа, үр дүн**

**ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАНД
ТАВИХ ДОТООД ХЯНАЛТЫГ
ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН
БАЙНА**

Өлгий

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар 3
Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4
Аудитын газрын дарга,тэргүүлэх аудитор М. Хуанган	Бүлэг 1. Төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар <i>Төсвийн зарцуулалтанд тавих дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна</i> 5-6
Аудитын менежер Х.Женисбек	<i>Цалингийн зардлын төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.</i> 6-7
Аудитор Х.Манаргүл	<i>Тээвэр шатахууны төсвийн зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй хэрэгжсэн байна</i> 7-9
	<i>Түлш халаалтын тооцооны өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна</i> 9
2017 оны 6 дугаар сар	<i>Нэмэлт санхүүжилтээс 1770,0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна</i> 9
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 95429524 дугаарын утсаар харилцана уу	Бүлэг 2 Санхүүгийн тайланд авлага өглөгийг дутуу тусгаж, төсвийн гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнажээ <i>Санхүүгийн тайланд авлага өглөгийг дутуу тусгаж, төсвийн гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнажээ</i> 10-12 <i>Нягтлан бодох бүртгэлийг шаардлагын хэмжээнд хөтлөөгүй байна.</i> 12-13 <i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна</i> 13
ХАЯГ:	
Аймгийн ЗДТГазрын байр 1 дүгээр давхар 107 тоот өрөө	Дүгнэлт14-
	Зөвлөмж: 15-
	Холбогдох байгууллагын санал: 16- Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
	Саналд өгсөн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Аймгийн Төрийн аудитын газрын 2017 оны аудитын төлөвлөгөөнд тусгагдсан, Дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Өлгий сумын ЗДТГазрын 2016 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийх, жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг хянаж баталгаажуулж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх санал зөвлөмж өгөхөд аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Энэхүү аудитад Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2016 оны үйл ажиллагааг бүрэн хамруулж, санхүүгийн болон ажлын тайлан, санхүүгийн баримтуудад үндэслэн хэрэгжүүлэв.

ÃŁéöyôãýëëí áóäè òëëääýõ ãñóóäëûí òàëààð ôâ÷ ìýäýëýë:

Өлгий сумын ЗДТГазар нь 2016 онд 485,9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 485,9 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулжээ. Нэмэлт санхүүжилтээр 12,9 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материалд тулгуурлан хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дүнд” гэж үнэллээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан Өлгий сумын Засаг даргын тамгын газрын холбогдох албан тушаалтнуудтай ярилцах, тайлбар лавлагаа авах, тулган шалгах, судалгаа авч дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

- 9.1 Төсвийн тухай хууль
9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9.2 НББ-ийн тухай хууль
9.3 Бусад хууль тогтоомж, эрхийн акт

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг аудитор Х.Манаргүл ахалж, аудитор Б.Үүрийнтуяа нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг 2017 оны 5 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэв.

Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2016 оны
үйл ажиллагааны үр дүн

Бүлэг 1

Төсвийн зарцуулалтанд тавих дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Оршил

Өлгий сумын Засаг даргын тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан тайлан мэдээг хугацаанд нь хариуцан гаргуулж, хяналт тавих, хүн ам, орон сууц, газар, мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах, нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Онцгой байдлын газартай хамтран Өлгий сумын ард иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар гамшигаас хамгаалах 2016 оны төлөвлөгөөг шинэчлэн баталж, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж хамтарч ажилласан байна.

Өлгий сумын ЗДТГазар нь 2016 онд удирдах 16, гүйцэтгэх 23, үйлчлэх 2 гэрээт 6 бүгд 47 орон тоогоор үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант оны 1-5 дугаар сард Х.Тилекберди, 6-12 дугаар сард Ш.Ауесхан нар нягтлан бодогчийн ажлыг хийж, санхүүгийн баримтанд 2 дугаар гарын үсэг зурж, тайлан тэнцэлийг гаргасан байна.

1.1.Төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар

Төсвийн зарцуулалтанд тавих дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Өлгий сумын ИТХ-ын 2016 оны 3-р сарын 17-ны өдрийн хуралдаанаар баталсан төсвийн тодотголоор ЗДТГазрын 2016 оны тодотгосон төсвийг 485879,3 мянган төгрөгөөр баталж, үүний 458014,0 мянган төгрөгийн төсвөөс санхүүжүүлэхээр, 27865,3 мянган төгрөгийг урьд оны үлдэгдэл санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр төсвөөс 140756,5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвийн орлогоос 345122,8 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийтдээ

480,383,6 мянган төгрөгийн зарлага санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж, 5952,6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарцуулалтыг зардлын зүйл анги тус бүрээр нь авч үзвэл:

Цалингийн зардал, НДШимтгэл, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, тээвэр шатахуун, бусад бараа үйлчилгээний зардлуудыг 50,0-4927,4 мянган төгрөгөөр хэтрүүлэн, гэрэл цахилгаан, түлш халаалтын зардал, шуудан холбоо, нормын хувцас, урсгал засвар, дотоод албан томилолт зэрэг зардлуудыг 18,5-4588.0 мянган төгрөгөөр хэмнэж, хэмнэлтийг хэтэрсэн зардлуудад гүйлгэн зарцуулж, оны эцэст 5952,6 мянган төгрөгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар цэрэг татлагын комиссыг 3 удаагийн хоол хүнсээр хангах, байгалийн 3 удаагийн үер, гамшигтай холбоотой төлөвлөгдөөгүй зардлууд гарсан нь зарим зардлууд хэтрэхэд нөлөөлсөн байна.

2016 онд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 7409,7 мянган төгрөг тусгагдсан боловч тухайн ажилтан тэтгэвэрт гараагүй тул 5952,6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлж, 1457,0 мянган төгрөгийг зохих зөвшөөрөлгүйгээр урсгал зардалд зарцуулж, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан "төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 7.2.3-т "Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг бусад зардалд шилжүүлэхийг хориглоно" гэсэн заалтг зөрчсөн тул нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Тайлант онд зардлын бүлэг хооронд 3428,7 мянган төгрөгийг зохих зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулж Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 дэх заалт, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант оны 5-р сарын 30-ны өдөр Хот тохижуулах албаны дансанд 2980,8 мянган төгрөгийг буруу гүйлгээ хийж шилжүүлсэнийг тооцоо хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагаар харуулаагүй, мөн аймгийн Төрийн сангаас зээлээр авсан 1500,0 мянган төгрөгийг тайланд өглөгөөр харуулаагүй байна.

1.2 Орон тоо, цалин хөлсний төсвийн зарцуулалтын талаар.

Цалингийн зардлын төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Тайлант онд цалингийн зардал 366,5 сая төгрөгийн төсөв хуваарилагдснаас 371,5 сая төгрөгийг зарцуулж 5,0 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Цалингийн зардлын төсвийн зарцуулалтыг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хэтрэлтийн хувь
1	ЗДТГазар	208,476.1	211,436.5	2,960.4	60.1
2	БЗДарга	158,069.5	160,036.4	1,966.9	39.9
ДҮН		366,545.6	371,472.9	4,927.3	100.0

Цалингийн сангийн төсвийн 56,9 хувийг ЗДТГазрын, 43,1 хувийг Багийн засаг дарга нарын цалин эзэлж байна. ЗДТГазар 211,4 сая төгрөгийг зарцуулж цалингийн санг 2,9 сая төгрөгөөр, Багийн засаг дарга нар 160,0 сая төгрөг зарцуулж 1,9 сая төгрөгөөр тус тус хэтрүүлжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолоор сумын Засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг 22 орон тоогоор тогтоосон байна. Өлгий сумын ЗДТГазрын даргын 2016 оны 1 дүгээр сарын 02 тоот тушаалаар ЗДТГазрын орон тоо бүтцийг үндсэн 22, гэрээт 3 бүгд 25 орон тоогоор баталсан боловч 6-р сараас Санхүүгийн алба шинээр байгуулагдаж, нэг орон тоог нэмж ажиллуулсан нь цалингийн сан хэтрэхэд нөлөөлсөн байна.

Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолын холбогдох хавсралтуудыг үндэслэн ЗДТГазрын ажилчдын цалин тогтоолт, албан тушаалын ангилал зэрэглэлийг шалгаж үзэхэд зөрүү гараагүй. Цалинг шинэчлэн тогтоосон тушаалын хавсралтанд ажил хавсран гүйцэтгэсэн, бусад нэмэгдлүүдийн хувь хэмжээг тодорхой тусгаж хавсаргаж байхыг аудитын явцад зөвлөж ажиллав.

Аудитын явцад НДХэлтсийн тооцоо нийлсэн акт болон 2016 оны татварын тайланг авч тулган баталгаажуулалт хийхэд НДШимтгэлийн тооцооноос зөрүү гараагүй. Харин дутуу төлөгдсөн 5648,6 мянган төгрөгийн ХХОАТатварыг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй байна. Үүнийг 2017 оны 1-р улирлын татварын тайлангаас хөөн шалгаж үзэхэд төлж барагдуулсан байна.

1.3 Тээвэр шатахууны төсвийн зарцуулалтын талаар.

Тээвэр шатахууны төсвийн зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

Тээвэр шатахууны зардалд 8401.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 8451,0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гаргасан байна. Аудитын явцад хийсэн түүвэр тооцоогоор тээвэр шатахууны зардалд нийтдээ 10144,6 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 2209,9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Өлгий сумын 5, 9, 11-р багуудын нутаг дэвсгэрт 2016 оны 6, 7, 8-р сард болсон үер, байгалийн гамшигийн үеэр байгууллагын төсвөөс төлөвлөгдөөгүй бензин шатахуун зарцуулсан нь тээвэр шатахууны төсөв хэтрэхэд нөлөөлжээ.

ЗДТГазрын дарга, мэргэжилтнүүдийн тайлант онд авч зарцуулсан бензин шатахууны тооцоог хийж үзэхэд дараах байдалтай байна.

/литрээр/					
Д/д	Шатахуун авсан албан тушаалтны нэр	Бүгд дүн	А-80	А-92	ДТ
1	Засаг дарга	1631	400	1230	0
2	ЗД-ын орлогч	530	425	105	-
3	ЗДТГ-ын дарга	535	305	205	25
4	Байцаагч нар	1526	370	1156	0
	ЗАА-ны ахлах ажилтан	85	10	75	
	БОХ улсын байцаагч	221	20	201	
	Газрын даамал	60	20	40	

	Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн	105	15	90	
	Худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	140	20	120	
	Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн	140	20	120	
	ХМА ажилтан	50	20	30	
	МЭ-ийн улсын байцаагч	235	160	75	
	Бичээч архив бичиг хэргийн эрхлэгч	20		20	
	Дотоод ажил хариуцсан ажилтан	50		50	
	Сүлжээ хариуцсан ажилтан	110	20	90	
	Бусад ажилтанууд	310	65	245	
5	Санхүүгийн алба	580	140	440	0
	Санхүүгийн албаны дарга	350	60	290	
	Төрийн сангийн төлөөлөгч	75		75	
	Ня-бо	35	25	10	
	Нярав	120	55	65	
6	Үерийн үед авсан бензин	1286	174	692	420
	НИЙТ ДҮН	6088	1814	3828	445

Шатахууны зардлын төсвийн зарцуулалтын бүтцийг хүснэгтээр харуулбал:
/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Мөнгөн дүнгээр	хувь
1	Засаг дарга	2,544.0	24.0
2	ЗД-ын орлогч	752.4	7.1
3	ЗДТГ-ын дарга	784.2	7.4
4	Байцаагч нар	2,379.6	22.4
5	Санхүүгийн алба	914.8	8.6
6	Үер болон бусад арга хэмжээнд	1,944.5	18.3
7	БЗДарга	1,291.5	12.2
	ДҮН	10,610.9	100.0

Шатахууны төсвийн зарлагын бүтцээс харахад сумын Засаг дарга 24,0 хувь буюу 2544,0 мянган төгрөгийг, Засаг даргын орлогч 7,1 хувь буюу 7752,4 мянган төгрөгийг, ЗДТГ-ын дарга 7,4 хувь буюу 784,2 мянган төгрөгийг, байцаагчид 22,4 хувь буюу 2379,6 мянган төгрөгийг, санхүү төрийн сангийн ажилтнууд 8,6 хувь буюу 914,8 мянган төгрөгийг, Багийн засаг дарга нар 12,2 хувь буюу 1291,5 мянган төгрөгийг, үер болон бусад үйл ажиллагаанд 18,3 хувь буюу 1944,5 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ. Сумын ЗДТГазрын ажилтнуудын хувийн унаанд бензиний талон олгохдоо ажлын зайлшгүй шаардлага гарсан учраас олгосон тухай ямар нэгэн тушаал, шийдвэр гаргаагүй байна.

Байгууллагын жолооч нь 2016 оны 5 дугаар сараас ажлаас гарч тамгын газрын машиныг сумын засаг дарга өөрөө барьж, машин байхгүй нэрийдлээр ажилтнуудын хувийн машинд бензин олгож байсан нь тээвэр шатахууны зардлыг хяналт муутай зарцуулахад хүргэж, шатахуун зарцуулалтын тооцоо хийгдээгүй, холбогдох журам эрхийн актыг хэрэгжүүлээгүй байна. Эхний 5 сард нягтлан бодогч нь зөвхөн бензин авсан хүмүүсийн нэрийн жагсаалт үйлдэж гарын үсэг зуруулсан байна.

Тайлант онд “Рысжан” ХХК-тай шатахуун нийлүүлэх гэрээ байгуулж, шатахууныг талонаар зээлээр авч, сарын эцэст тооцоо хийж, төлбөрийг төлж байжээ. Шатахууны жилийн эцсийн тооцоо нийлэхэд 2241,1 мянган төгрөгийн

өглөгтэй гарсаныг санхүүгийн тайланд өглөгөөр харуулаагүй байна. Нягтлан бодогч Х.Тилекберди 1-5 дугаар сард 1103,0 мянган төгрөгийн 725 л, нягтлан бодогч Ш.Ауесхан 6-12 дугаар сард 2321 л бүгд 4530,8 мянган төгрөгийн 3046 л шатахууныг Тамгын газрын даргын цохолт хийсэн гарын үсэггүй, зөвхөн нягтлан бодогчийн гарын үсгээр олгосон нь ЗДТГ-ын дарга нь төсвийг захиран зарцуулах эрх үүргээ биелүүлээгүй, бензин шатахууныг зарцуулалтанд хяналт тавиагүй бөгөөд үүнийг далимдуулан нягтлан бодогч нар эрх хэмжээгээгээ хэтрүүлэн бензин шатахууныг дур мэдэн зарцуулж ирсэн байна.

1.4 Түлш халаалтын зардлын төсвийн зарцуулалтын талаар.

Түлш халаалтын тооцооны өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Түлш халаалтын зардалд 32920,3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 28332,3 мянган төгрөгийг төлж 4588,0 мянган төгрөөр хэмнэсэн байна.ЗДТГазар нь 2016 онд “Эрчим баян” ХХК-тай халаалтын гэрээ байгуулаагүй, тооцоо нийлж, тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Аудитын явцад халаалтын нэхэмжлэл, бусад холбогдох материалыг үндэслэн тооцоо хийж үзэхэд оны эцэст 6674,5 мянган төгрөгийн өглөгтэй гарсаныг жилийн эцсийн санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй нуун дарагдуулсан байна.

Аудитын дүнгээр “Эрчим баян” ХХК-тай халаалтын гэрээг шинэчлэн хийж, жилийн эцсийн тооцооны үлдэгдлийг баталгаажуулж санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж байхыг албан шаардлагаар үүрэг болгов.

1.5 Нэмэлт санхүүжилтийн төсвийн зарцуулалтын талаар.

Нэмэлт санхүүжилтээс 1770,0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар нийтдээ 12928,1 мянган төгрөгийн орлого хүлээн авч зарцуулжээ. Аймгийн ИТХурлын тэргүүлэгчдийн 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 82 тоот тогтоолоор орон нутгийн өмчийн орлогоос Өлгий сумын цагдаагийн ажилтнуудын урамшууллд 4800,0 мянган төгрөгийн, ХХААГазраас малын вакцинжуулалтын ажлын хөлсөнд 7388,1 мянган төгрөгийн, бусад орлогоос 740,0 мянган төгрөгийн орлого хүлээн авчээ.

Гүйцэтгэлээр 7388,1 мянган төгрөгийг малын вакцинжуулалтын ажлын хөлсөнд, 2970,0 мянган төгрөгийг цагдаагийн ажилтнуудын урамшуулалд, 1770,0 мянган төгрөгийг урьдчилгаа цалинд, 225,0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд, 575,0 мянган төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардалд зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн данснаас хувь хүмүүст 1770,0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож, суутгаагүй жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага үүсгэсэн байна.

Бүлэг 2

Санхүүгийн тайланд авлага өглөгийг дутуу тусгаж, төсвийн гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнажээ.

2.1. 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн талаар.

Санхүүгийн тайланд авлага өглөгийг дутуу тусгаж, төсвийн гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнажээ.

Өлгий сумын Засаг даргын тамгын газар нь Аудитын газарт 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2016 оны 2 дугаар сарын 20-ны өдөр хугацаа хожимдуулан ирүүлж Төсвийн тухай хуулийн 8.9.1-д “төсвийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн.

Санхүүгийн тайланг хугацаа хожимдуулж ирүүлсэний дээр аудитын дүгнэлт хийхэд шаардлагатай санхүүгийн баримт материалуудыг ирүүлээгүйгээс аудитын дүгнэлтийг дэмжих нотлох зүйл цуглуулах боломжгүй болж дүгнэлт өгөхөөс татгалзаж, нягтлан бодогчид хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн.

Гүйцэтгэлийн аудитаар 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргалтын байдлыг түүвэрлэн шалгаж үзэхэд Санхүүгийн үр дүнгийн тайланд 1275,0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг дутуу тайлагнаж, Төсвийн гүйцэтгэлийн тайланд цалингийн зардлыг 1322,5 мянган төгрөгөөр, НДШимтгэлийг 1730,3 мянган төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 499,0 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардлыг 1832,8 мянган төгрөгөөр тус тус дутуу, түлш халаалтын зардлыг 3048,7 мянган төгрөгөөр, шуудан холбоо зардлыг 615,5 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 1576,6 мянган төгрөгөөр, аудит, баталгаажуулалтын зардлыг 144,0 мянган төгрөгөөр илүү, бүгд 5384,8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлжээ.

Мөн жилийн эцсийн тооцоогоор үүссэн Хот тохижуулах албанаас авах 2980,8 мянган төгрөгийн авлага, 16064,2 мянган төгрөгийн татвар, шатахуун, халаалт, төрийн сангийн зээлийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд тусгаж харуулаагүй орхигдуулсан байна.

Дээрхи алдаа зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон бусад тайлан мэдээг үнэн зөв гаргах”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, авлага”, 14.4.3-т “бүх өр төлбөр” гэсэн заалт болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал”-ын холбогдох заалтуудыг зөрчиж байгаа тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.

Өлгий сумын ЗДТГазрын аудитлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	485,879,300	480,383,588	-5,495,712
УРСГАЛ ЗАРДАЛ	485,879,300	480,383,588	(5,495,712)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	478,469,600	480,383,588	1,913,988
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	366,545,600	371,473,012	4,927,412
Үндсэн цалин	300,843,400	305,770,812	4,927,412
Нэмэгдэл	38,637,900	38,637,900	-
Унаа хоолны хөнгөлөлт			-
Гэрээт ажлын хөлс	27,064,300	27,064,300	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,319,200	41,554,924	1,235,724
Тэтгэврийн даатгал	40,319,200	41,554,924	1,235,724
Тэтгэмжийн даатгал			-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,354,400	34,067,520	(3,286,880)
Гэрэл, цахилгаан	1,956,100	2,972,951	1,016,851
Түлш, халаалт	32,920,300	28,332,254	(4,588,046)
Цэвэр, бохир ус	2,478,000	2,762,315	284,315
Хангамж, бараа материалын зардал	17,303,100	15,886,886	(1,416,214)
Бичиг хэрэг	3,735,700	3,497,101	(238,599)
Тээвэр, шатахуун	8,401,000	8,451,000	50,000
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,166,400	3,938,785	(1,227,615)
Нормативт зардал	224,000	205,500	(18,500)
Нормын хувцас, зөөлөн эдлэл	224,000	205,500	(18,500)
Эд хогшил, урсгал засварын зардал	1,569,700	1,409,600	(160,100)
Урсгал засвар	1,569,700	1,409,600	(160,100)
Томилолт, зочны зардал	3,673,500	2,083,600	(1,589,900)
Дотоод албан томилолт	3,673,500	2,083,600	(1,589,900)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,784,300	7,058,231	273,931
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,506,300	6,049,346	543,046
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	480,000	336,000	(144,000)
Даатгалын үйлчилгээ	25,000	25,000	-
Тээврийн хэрэгслийн татвар	65,000	87,720	22,720
Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000	20,000	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	563,000	461,185	(101,815)
Газрын төлбөр	40,000	40,000	-
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	85,000	38,980	(46,020)
Бараа үйлчилгээний бусад зардал	4,695,800	6,644,315	1,948,515
Бараа үйлчилгээний бусад зардал	4,385,800	6,364,595	1,978,795
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	310,000	279,720	(30,280)

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,409,700	-	(7,409,700)
Бусад урсгал шилжүүлэг	7,409,700	-	(7,409,700)
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,409,700		(7,409,700)
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	485,879,300	479,926,700	(5,952,600)
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	485,879,300	479,926,700	(5,952,600)
Орон нутгийн төсвөөс	485,879,300	479,926,700	(5,952,600)

2.2. Байгууллагын өмч хөрөнгөнд тавих дотоод хяналтын талаар

Нягтлан бодох бүртгэлийг шаардлагын хэмжээнд хөтлөөгүй байна.

Байгууллагын нягтлан бодогч нь аудитын явцад харилцахын дэлгэрэнгүй бүртгэлээс өөр журнал ирүүлээгүй бөгөөд бусад нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөл зохих журнал, туслах, ерөнхий дэвтэрийг огт хөтлөөгүй байна. Санхүүгийн анхан баримтын бүрдүүлэлт хангалтгүй, кассын тайланг зохих журмын дагуу гаргаж, тооцоо хийгээгүй байна. Сүүлийн хагас жилийн кассын тайланг /2471,3 мянган төгрөг/ удаа дараа шаардуулж аудитын хугацаа дуусах үед авч ирсэн. Үүнээс үзэхэд нягтлан бодогч Ш.Ауесхан нь НББ-ийн тухай хуулийн 20.2-т заасан нягтлан бодогчийн үүргээ биелүүлээгүй байна.

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг Сангийн сайдын 2002 оны 171/191 дүгээр тушаалаар баталсан маягт зааврын дагуу бүрэн хөтөлж, кассын тайланг сар бүр гаргуулах, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж, НББ-ийн тухай хуулийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт, бичиг, мэдээ мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэлийн ажилд “Аколоус” программыг бүрэн ашиглах шаардлагатай байна.

Өлгий сумын ЗДТГазрын даргын 2016 оны 29 дүгээр тушаалаар томилогдсон тооллогын комисс хөрөнгийн хагас жилийн тооллогыг, 2017 оны 01 дүгээр тушаалаар томилогдсон тооллогын комисс хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийж, эд хариуцагч бүрээр хөрөнгийн ашиглалтын бүргэлийг үндэслэн тооцоо хийж үлэгдлийг баталгаажуулсан байна. Тооллогын дүнгээр дутагдсан 4 төрлийн 3075,0 мянган төгрөгийн эд хөрөнгийг хариуцах эздээр нь төлүүлэхээр шийдвэр гаргуулж, хуулийн байгууллагад шилжүүлжээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд байгууллагын 2016 оны батлагдсан төсөв, гүйцэтгэлээс бусад мэдээлэл, 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, аудитлагдсан тайланг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Тус аудитын газраас 2016 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд нийцлийн аудит хийгдэж холбогдох арга хэмжээ авагдсан болно.

Гүйцэтгэлийн аудитын дүнгээр тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлаас зориулалт бус зарцуулсан 1457,0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Мөн жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаж харуулаагүй 2980,8 мянган төгрөгийн авлага, 16064,2 мянган төгрөгийн бүгд 19045,0 мянган төгрөгийн өглөгийг 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар тооцоонд оруулж залруулах, мөн зардлын бүлэг хооронд зохих зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан 4885,7 мянган төгрөгийн, төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнасан 5384,8 мянган төгрөгийн, Тамгын газрын даргын зөвшөөрөлгүй олгосон 4530,8 мянган төгрөгийн шатахуун, кассаас бүрдэл дутуу баримтаар зарцуулсан 2471,3 мянган төгрөгийн нийтдээ 17272,6 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Төсвийн зарцуулалтанд тавих дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
2. Жилийн эцсийн санхүүгийн тайланд авлага, өглөгийг бүрэн тусгаж харуулаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнасан байна.
3. Нягтлан бодогч нь НББ-ийн тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй байна.
4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Тайланг баталгаажуулсан:

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор

М.Хуанган

Тайланг хянасан:

Аудитын менежер

Х.Женисбек

Тайланг бэлтгэсэн :

Аудитор

Х.Манаргүл

Холбогдох байгууллагын санал